

**ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 12 дугаар сарын 07

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин			Хүрэх түвшин	Төсөв	Хугацаа	Хариуцах эзэн	Хувь
				Он	Түвшин	Түвшин					
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
1	Хүний хөгжлийг дэмжих жилийн хүрээнд албан хаагчдад аймаг, улсаас зохион байгуулсан дэмжлэг, тусламжид хамруулах	Дэмжлэгт хамрагдсан албан хаагчдын тоо	тоо	2022	1	1	Аймгийн хүний нөөцийн хөтөлбөр 5 сая	2-12 сар	Хүний хөгжлийг дэмжих ажлын хүрээнд Архив, бичиг хэргийн ажилтныг Архивын ерөнхий газраас жил бүр зохион байгуулагддаг "Архив албан хэрэг хөтлөлтийн ажилтныг мэргэшүүлэх" анхан шатны 30 хоногийн сургалтад хамруулан 250,000 төгрөгийн төлбөр, няравыг сертификаттай мэргэшүүлэх сургалтад хамруулан 100,000 төгрөгийн төлбөрийг тус тус байгууллагаас бүрэн хариуцан мэргэшүүлсэн. Мөн албан хаагчдын ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор санхүүгийн өрөөг бүрэн засварласан.	100	
2	Албан хаагчдаас ажлын байрны орчин нөхцөл, тоног төхөөрөмжийн хангалтын талаар сэтгэл ханамжийн санал, асуулга авах	Судалгаанд хамрагдан санал өгсөн албан хаагчдын тоо	тоо	2022	14	15	-	6 сард	5 дугаар сард судалгааны 5 асуулгын хүрээнд 17 албан хаагчыг хамруулан сэтгэл ханамжийг авч нэгтгэж үзэхэд ширээ сандал шинэчлэл хийх шаардлагатай гэж 35.2 хувь, интернэтийн хурдыг сайжруулах гэж 41.17 хувь, сэтгэл хангалуун гэж 23.63	100	

										хувь үзсэн. Судалгааны дагуу байгууллагын интернэтийн хурдыг 10тг болгон нэмэгдүүлж, 5 албан хаагчийн ажлын ширээ сандлыг шинэчлэн дахин судалгааг авахад 16 албан хаагч 100 хувийн сэтгэл ханамжтай гэж ирүүлсэн. Интернэтийн хурдны зөрүүд 1,007,000 төгрөг зарцуулсан.	
3	Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтийн үр дүнг хэргэлзэн харгалзан тогтоомжийн хүрээнд цалингийн шатлал ахиулах, зэрэг дэв олгуулах, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох.	Цалингийн шатлал, зэрэг дэв, мөнгөн урамшуулал олгосон ажилчидын тоо	тоо	2022	15	15	УТ 9 сая	12 сарын 15-ны дотор		Төрийн албаны тухай хуулийн дагуу 4 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулсан. Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалингийн сүлжээнд өөрчлөлт орж нэмэгдсэн. Төрийн үйлчилгээний 7 албан хаагчдад үр чадвар, үр дүнгийн нэмэгдэлд 11,787,202 төгрөг, 3 албан хаагчид балансын урамшуулалд 3,345,400 төгрөг, төрийн захиргааны 4 албан хаагчид үр дүнгийн урамшуулалд 2,739,938 төгрөг, улс төрийн 4 албан хаагчид 3,627,500 төгрөг буюу нийт давхардсан тоогоор 18 албан хаагчид 21,500,040 төгрөг тус тус олгосон байна.	100
	Төсвийн зардлын хэмнэлтийг харгалзан албан хаагчдад түлээ, нүүрсний хөнгөлөлт үзүүлэх.	Хөнгөлөлтөд хамрагдсан албан хаагчийн тоо	тоо	2022	15	15	УТ 3 сая	12 сарын 15		Түлээ, нүүрсний хөнгөлөлтийг 15 албан хаагчид 5,737,500 төгрөгийг олгосон.	100
5	Албан хаагчдын гэр бүлийн нөхцлийг судлан хамт	Зохион байгуулсан	тоо	2022	0	1	Хамтын сан	2-4		Олон улсын хүүхдийн эрхийн хамгаалах	

	олонтойгоо танилцуулах, үр хүүхдүүдийн хамтаар агаар салхинд гаргах	арга хэмжээний тоо						0,5 сая	улиралд	тохиолдуулан хаагчдыг гэр бүл, хүүхдүүдийн хамт агаар салхинд гаргаж байгалийн үзэсгэлэнт газар Сүм хөх бүрдэд нэг өдрийн арга хэмжээг зохион байгуулсан. Энэ арга хэмжээнд 860,000 төгрөгийг хамтын сангаас зарцуулсан.	100
6	Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн болон улсын нарийн мэргэжлийн эмчийн оношлогоо шинжилгээнд хамруулж, архаг өвчтэй ажилтнуудыг эмчийн болон эмнэлгийн хяналтанд авч эрүүл мэндийн тусламж дэмжлэг үзүүлэх,	Үзлэгт хамрагдсан албан хаагчийн тоо Эрүүлжсэн албан хаагчийн тоо	18	18	2022	тоо		УТ 2 сая, Хувь 5 сая	3-р улиралд	Улаанбаатар хотын улсын 2-р төв эмнэлгийн эмч нарын үзлэгт 15 албан хаагч, эрт илрүүлэг үзлэгт 18 албан хаагч 100 хувь хамрагдсан. Дээд шатлалын эмнэлэгт хандах 4-н албан хаагч Улаанбаатар хотод нарийн оношлогоо шинжилгээнд хамрагдаж 2 албан хаагч эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн, 1 албан хаагч БНСУ-д нарийн үзлэгт хамрагдаж 3 сарын дараа давтан үзлэгтээ хамрагдаж ирсэн. Үзлэгт давхардсан тоогоор 33 албан хаагч хамрагдаж эрүүлжсэн албан хаагч 3, байнгын хяналтад 2 албан хаагч байдаг.	100
7	Албан хаагчдыг шагналд тодорхойлох.	Шагнуулсан албан хаагчийн тоо	2	2	2022	тоо			1-4 улиралд	Сумын Засаг даргын "Жуух бичиг"-ээр 2 албан хаагчийг, "Соёлын тэргүүний ажилтан" цол тэмдгээр 1 албан хаагч, аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр 2 албан хаагч, "Хүндэт тэмдэг"-ээр 1 албан хаагч, Залуучуудын холбооны "Тэргүүний залуу" алтан медаль 1 албан	100

										хаагчийн тодорхойлолтыг тус тус хүргүүлээ.	
8	Албан хаагчдын цалин урамшууллын талаарх мэдээлэл, өөрчлөлтийг хүний нөөцийн системд тухай бүр оруулах	Мэдээлэл оруулсан тоо	тоо	2022	3	4	-	2-р улиралд	100	Байгууллагын 18 албан хаагчийн цалингийн өөрчлөлтийг 2 удаа, шинээр ажилд орсон 6, гарсан 4 албан хаагчийн мэдээллийг тус тус програмд оруулсан.	
9	Албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хэсэгчлэн хангах ажлыг зохион байгуулах	Нэмэгдсэн тоног төхөөрөмжийн тоо	тоо	2022	-	1	УТ 3 ая	1-4 улиралд	100	Байгууллагын хэмнэсэн зардлаас 36,4 мкв 2 өрөөнд дотор засвар хийж тохижуулан, ширээ, сандалыг шинэчилсэн. Нийт зардал 8,090,000 төгрөг. Терийн сангийн мэргэжилтэн болон дотоод ажил хариуцсан албан хаагчид АЗ өнгөт принтер 2,600,000 төгрөгөөр, таблет 2 ширхэгийг 3,700,000 худалдан авахаар төсөвт зохицуулалт хийж захиалсан. Аймгийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 1 суурин компьютер, 4 нөтбүүк, 1 мотоцикль шийдвэрлэж өгсөн.	
10	Байгууллагын эрэгтэй ажилчдыг өвс, тэжээл буулгах болон байгаль цаг уурын өөрчлөлтийн үед өмсөх ажлын хувцастай болгох	Хувцасны хангалтын тоо	тоо	2022	3	3	Хэмнэ гдсэн орлог 0	1-4 улирал	100	Өмнөх онд авсан 3 хувцаснаас 1 нь элэгдэж ачлагдсан, шинээр 1 хувцас 150,000 төгрөгөөр хийлгэсэн.	
11	Байгууллагын харьяат ахмадуудад дэмжлэг тусламж үзүүлэх, ахмадын баяр, цагаан сараар хүндэтгэл үзүүлэх,	Дэмжлэг хамрагдсан ахмадын тоо	тоо	2022	65	65	УТ 5 сая	2 болон 10 дугаар сард		Байгууллагадаа харьяатай 61 ахмадад цагаан сараар 1,830,000 төгрөг, ахмадын баяраар 192,000 төгрөг, хуваарийн дагуу зохион байгуулдаг "Дуулах өдөр"	

										дуун цэнгүүнийг 2 удаа хариуцан зохион байгуулж 150 гаруй ахмад хамрагдаж 426,000 төгрөг, Эрдэнэдалай суманд зохион байгуулагдсан арга хэмжээнд 24 ахмад оролцож 124л шатахуун буюу 308,760 төгрөгийг зарцуулж үйл ажиллагааг нь дэмжин ажиллаж байна. Нийт давхардсан тоогоор 235 ахмад настанд 2,756,760 төгрөгийг зарцуулсан байна.	100
12	Албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор цас месны баяр, явган аялал, тойрон аялал жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	тоо	2022	1	1	УТ 500 мян	1-11 сард	Ажилчдын амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдгээрийн эрүүл мэндийг дэмжих, агаар салхинд гаргах зорилгоор цанын баазад 2 өдрийн арга хэмжээ зохион байгуулсан. Уг арга хэмжээний зардалд хамтын сангаас 800,000 төгрөгийг зарцуулсан.	100	
13	Албан хаагчдын дархлааг дэмжин хүйтэн сэрүүний улиралд ажлын байранд сондгой өдрүүдэд халуун аарц, чацаргана өгөх	Дархлааг дэмжсэн арга хэмжээ өдрөөр	Өдрийн тоо	2022	30	30	УТ 500 мян	11-12 сард	Албан хаагчдын дархлааг дэмжих, хүйтэн сэрүүний улиралд ханиад томуу, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын зардлаас 30л аарц худалдан авч 7 хоног 3 удаа халуун аарцаар үйлчилж 318,000 төгрөг зарцуулсан. Зарцуулсан хүн өдөр 24 хоног.	80	
14	Санхүүгийн албан хаагчдыг Санхүүчдийн баярын тэмцээнд оролцуулах.	Оролцсон албан хаагчийн тоо	тоо	2022	1	2	-	11-12 сард	Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Санхүүчдийн баярын арга хэмжээнд 2 албан хаагчийг тэмцээнд оролцуулсан.	100	

15	Албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор спорт залтай гэрээ хийж тоглолтын өдөртэй болох	Гэрээ хийсэн эсэх	Тийм үгүй	2022	1	1	УТ 800,00 0 төгрөг	1-12 сард	Албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 7 хоногийн лхагва гариг бүр зааланд тоглох гэрээг сургуулийн захиралтай байгуулан 880,000 төгрөгийг зарцуулсан.	Санхүүгийн албаны ажилчиддаа байгууллага бүр 100,000 төгрөг зарцуулан хүндэтгэл үзүүлсэн. Хамрагдсан албан хаагч 4	100
Хэрэгжилтийн хувь:											
Зарцуулсан төсөв: 48,849,260											
98.6											

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Б.ГАНЧИМЭГ